

БАТЛАВ  
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.МӨНГӨНХӨЛӨГТ



*Handwritten signature*

оны ..... дүгээр сарын 29

## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2023 оны 11 дүгээр сарын 10

№ ДО 23/33

Багануур дүүрэг

1. Техникийн нөхцөл  
хүссэн хуулийн этгээд:

Сайншанд сумын засаг дарга

2. Хэрэглэгчийн хаяг:

Сайншанд сумын ЗДТГ-ын байр, Залуучуудын  
гудамж, 3-дугаар баг, Дорноговь аймаг,  
Сайншанд сум  
Утас: 70523167

3. Хэрэглэгчийн байршил,  
зэрэглэл:

Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, 8-р  
баг  
3-р зэрэглэл

4. Ажил үйлчилгээний  
зориулалт:

Авто замын гэрэлтүүлгийн цахилгаан хангамж

5. Техникийн нөхцөл  
олгох үндэслэл:

2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн  
03/1443 дугаартай албан бичиг

6. Хэрэглээний нийт чадал:

120 кВт

7. Холбогдох цэг:

7.1 Сайншанд сум 10 кВ-ын РП-1-ийн Нефть  
цахилгаан дамжуулах агаарын шугамаас  
тэжээлтэй **250 кВА** чадалтай 10/0.4 кВ-ын  
АТП-57 дэд өртөөг буулгаж шинээр **400 кВА**  
чадалтай 10/0.4 кВ-ын хүчний  
трансформатор бүхий иж бүрэн КТПН  
маягийн дэд өртөөг барина.

7.2 10/0.4 кВ-ын дэд өртөөний 10 кВ талд  
цэнэг шавхагч, ачаалал таслагч, гал  
хамгаалагч, 0.4 кВ талд нь ачаалалдаа  
тохирсон ерөнхий рубильник, гал  
хамгаалагч, цэнэг шавхагч, гаргалгааны  
автомат бүхий иж бүрэн тоноглол  
суурилуулна.

7.3 Шинээр угсарсан дэд өртөөг 10 кВ-ын 3\*50 мм<sup>2</sup>-аас багагүй хөндлөн огтлолын талбайтай газарт булах зориулалттай цахилгаан дамжуулах кабель шугам татаж тэжээнэ. 0.4 кВ талаас ачаалалдаа тохирсон газарт булах зориулалттай 0.4 кВ-ын кабель шугам татаж үйлдвэрлэл, үйлчилгээний барилгыг цахилгаан эрчим хүчээр хангана. 10/0.4 кВ-ын АТП-57 дэд өртөөнөөс тэжээгдэж байсан хэрэглэгчдийг хүчин чадал нэмэгдүүлсэн шинэ дэд өртөөнд шилжүүлж тэжээнэ.

## 8. Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 Шинээр угсрах 10/0.4 кВ-ын дэд өртөөний 0.4 кВ талд Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилтад орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан, гэрчилгээтэй, IEC 61861-1 стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, IEC 62052-11, IEC 62053-22, IEC 62053-24 стандартын шаардлага хангасан “БЗӨБЦТС” ТӨХК-д ашиглагдаж буй “Ухаалаг тоолуурын системд”-д ВРLС модуль бүхий дата концентраторын тусламжтайгаар мэдээллийг бүрэн дамжуулж интеграци хийх боломжтойгоор программчлагдсан 0.5S нарийвчлалтай, олон үйлдэлт 5 А-ын ухаалаг тоолуур, дата концентраторын (өгөгдөл дамжуулагчийн) хамт суурилуулна.

## 9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр угсрах 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, техникийн нөхцөл олгогчоор хянуулж, магадлан хяналтаар баталгаажуулна.

9.2 Шинээр угсрах 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугамын трассын зураг, схемийг Дорноговь ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 Шинээр угсрах 10/0.4 кВ-ын дэд өртөөний газардуулгын байгууламжийн тооцоог хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэж, “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн дагуу газардуулга хийнэ.

**9.4** Шинээр угсрах 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөө нь бусдын эзэмшлийн газар, инженерийн байгууламжийг огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл авна.

**9.5** Дорноговь аймгийн газрын албанаас шинээр баригдах 10/0.4 кВ-ын дэд өртөөний байрлал, 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугамын трассын дагуу газрын зөвшөөрөл авч баталгаажуулан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

**9.6** Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн  $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, байгаль экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж суурилуулна.

**9.7** Шинээр угсрах 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг “Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл”-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

**9.8** Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай хэмжилт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Дорноговь ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

**9.9** Хэрэглэгч нь 10 кВ-ын РП-1-ийн 10 кВ-ын Нефть гаргалгааны реле хамгаалалтын тавилын тооцоог БЗӨБЦТС ТӨХК-иар хийлгэнэ.

**9.10** Хэрэглэгч нь 10 кВ-ын РП-1-ийн 10 кВ-ын Нефть гаргалгааны ачааллыг тооцож, шаардлагатай тохиолдолд гүйдлийн трансформаторыг солино.

**9.11** Шинээр суурилуулах 10/0.4 кВ-ын КТПН маягийн дэд өртөөнд “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн дагуу хашаа хийнэ.

**9.12** Тухайн хэрэглэгч нь түгээх сүлжээнд холбогдсон нөхцөлд цахилгааны хэрэглээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагаа нь түгээх сүлжээний үндсэн параметр болох хүчдэл, давтамжийн утганд нөлөөлж нэгдсэн сүлжээний дүрмэнд заасан зөвшөөрөгдөх утгаас хэлбэлзэх, огцом буурах, өсөх, тоноглолын ачаалагдах хэмжээ зөвшөөрөгдөх хязгаараас давах мөн байгалийн онц ноцтой хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн түгээх сүлжээний үйл ажиллагаа доголдох, саатах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түгээх сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангахын тулд хугацаа харгалзахгүй цахилгаан эрчим хүчээр хязгаарлах, түдгэлзүүлэх нөхцөлөөр холбогдоно.

**9.13** 10/0.4 кВ-ын хүчин чадал нэмэгдүүлж байгаа дэд өртөөнөөс буусан материал, 250 кВА чадалтай дэд өртөөг тээвэрлэх зардлыг хэрэглэгч хариуцна. Дэд өртөөг тээвэрлэж, буулгах байрлалыг Дорноговь ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай зөвшилцөнө.

**10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

**10.1** Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 3.1-3.5 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн “Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтад хүлээн авах журам”-ын дагуу холбогдоно.

**10.2** Цахилгаан тоноглол болон агаарын шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Дорноговь ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

**10.3** Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**10.4** Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**10.5** Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

**10.6** Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**10.7** Хэрэглэгч нь “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

**10.8** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана.

2.17 Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1 Хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2 Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3 Холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн.

**10.9** Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

Сайншанд

№ 067/2023

2023.10.31

Дорноговь аймаг Сайншанд сумын 4, 7-р баг авто замын гэрэлтүүлгийг цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцлийг дараах байдлаар техникийн нөхцөл олгож байна.

**Байрлал:** Дорноговь аймаг Сайншанд сум 3-р баг.

**Үндэслэл:** Дорноговь аймаг засаг даргын тамгын газар 2023 оны 10-р сарын 26-ны өдрийн № 01/1401 тоот албан бичиг. Сайншанд ЦШС-ний хэсгийн санал.

**Зориулалт:** Авто замын гэрэлтүүлэг.

**Холболтын цэг:** Гэрэлтүүлэгт хамгийн ойр щитнээс

**Хэрэглэх хүчдэл, хүчин чадал:** 7.35/0.4 кВт

**Шаардлага:** Авто замын гэрэлтүүлгийн цахилгаан тэжээл нь:

1. КТП-7 дэд станцын дэргэд шинээр шит байрлуулж гэрэлтүүлгийг хүчдэлд холбох.
2. Шинээр тавигдах шит нь 60\*120 харьцаатай том байх, тус шитэнд гэрэлтүүлгийн чадалд тохирсон автомат, тоолуурыг суурьлуулах.
3. Гэрэлтүүлгийн тэжээлийг АВВГЗ\*50 хөндлөн огтлолын талбайтай кабель шугамаар холбох шаардлагатай.
4. КТПН-1 ДС-ын айлууд гаргалгааны 0,4 кВ-ын шит №68-ын дэргэд 50\*60 харьцаатай шит байрлуулах, тус шитийг гэрэлтүүлгийн чадалд тохирсон автомат, тоолуураар тоноглох АВВГЗ\*50 кабель шугамаар холболт хийх.
5. КТПН-5 дэд станцын Сотын байр гаргалгааны 0,4 кВ-ын АШ-ын шит №54-ын дэргэд шинээр 50\*60 харьцаатай шит байрлуулах автомат, тоолуураар тоноглох, АВВГЗ\*50 КШ-аар холболлт хийх. Бүх шитэнд газардуулга хийх.
6. Тоолуур нь Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажсан байх.
7. Щитэнд газардуулга хийж мэргэжлийн байгууллагаар туршиж баталгаажуулсан акттай байна.
8. Тэжээлийн кабель шугам авто зам хөндлөн гаргахдаа зориулалтын хоолойгоор сүвлэх.
9. Кабель шугамын нүх ухахдаа холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч ажлыг эхлүүлэх.
10. Гэрэлтүүлгийн щитэнд 0.4 кВ-ын щитэнд 3 фазын автомат 50 А, хэт хүчдэлийн хамгаалалт, цагийн болон хугацааны реле бусад тоноглолоор тоноглох.
11. Бүх ажлуудыг Цахилгаан байгууламжийн болон барилгын норм дүрмийн дагуу цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын

- аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж, хангагчийн техникийн комиссоор шалгуулж, шаардлагатай актуудыг бүрдүүлсний дараа хүчдэлд холбоно.
12. Кабель шугамын трассыг Говь-Сүмбэр аймгийн хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан сонгож, кабель шугам нь зам талбай хөндлөн гарах үед зориулалтын хоолойгоор гаргаж хамгаалах.
  13. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээний техник ашиглалтын хэвийн байдал, галын аюулгүй байдлыг бүрэн хуриуцаж, түгээгчийн шугам сүлжээ, тоноглолд гэмтэл учруулахгүй байхыг хуриуцна.
  14. Цахилгаан эрчим хүч хэрэглэх гэрээг ЭХУХ-ийн 2-р ангийн борлуулалтын инженертэй байгуулж, тус ангийн даргаар батлуулах, цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу урьдчилсан төлбөр төлж, цаашдын төлбөр тооцоог зохих журмаар хийж байх.
  15. Цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрөө хугацаанд нь барагдуулаагүй болон ЭХ-ний хууль, цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Цахилгаан байгууламжийн угсралт, Техник ашиглалтын дүрэм, олгосон техникийн нөхцлийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түтгэлзүүлэх болно.
  16. Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасаны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах, хэвийн бус ажиллагаатай үед өөрийн хөрөнгөөр засвар, үйлчилгээг хийх.
  17. Цахилгаан хэрэглэгч III зэрэглэлд хамаарна.
  18. Цахилгаан хангамжаар олгож буй техникийн нөхцөл I жилийн хугацаанд хүчинтэй.
  19. Цахилгаан шугам сүлжээ нь бусдын эзэмшил газраар дайрч гарах нөхцөлд тухайн газар эзэмшигчтэй зөвшилцөх, орчны тохижилтыг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэхийг хэрэглэгч бүрэн хариуцна.

Комиссын дарга:

Ерөнхий инженер:

П.Тайвантөр

Комиссын гишүүн:

Ашиглалтын инженер:

О.Алтангэрэл

Засварын инженер:

О.Очбаяр